

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН НЭГЖҮҮДИЙН  
2022 ОНЫ 12 ДУГААР САРЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.01.05

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“ГТХЗНТ” УТУГ-ын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тулгуурлан батлуулсан нэгжүүдийн 12 дугаар сарын төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал зөвлөмж боловсруулах, удирдлага, ажилтнуудыг мэдээллээр хангаж, үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, хэрэгжилт хариуцлагыг сайжруулах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний аргачлал**

Нэгжүүдийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэлийг төлөвлөгөөнд урьдчилан тодорхойлсон шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хүлээгдэж буй үр дүнтэй харьцуулж хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд заасан аргачлалаар үнэлэв.

**Үнэлэлт**

Нэгжүүдийн сарын төлөвлөгөөнд тусгагдсан ажлын хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтээр үзүүлэв.

Нэгжийн нэр	Төлөвлөсөн ажил	Үүнээс							Биелэлт /хувиар/
		100%	90%	70%	50%	30%	0%	ХБ	
ЗСХ	25	16	-	3	2	-	4	-	76.4
ТНУАСХ	8	8	-	-	-	-	-	-	100
ГХБАБМХ	7	7	-	-	-	-	-	-	100
<b>Дүн</b>	<b>40</b>	<b>31</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>-</b>	<b>85.3</b>

**Санал дүгнэлт:**

1. ЗСХ-ийн 2022 оны X сарын төлөвлөгөө 72.9 хувь, XI сарын төлөвлөгөө 56.7 хувь, XII сарын төлөвлөгөө 76.4 хувь, IV улирлын дүнгээр 70.9 хувийн биелэлттэй үнэлэгдсэнд дүгнэлт хийж удирдлагаас анхаарал хандуулах шаардлагатай байна.

2. ЗСХ-ийн дарга нь өнгөрсөн оны III сараас зайнаас ажиллах хөдөлмөрийн гэрээг хугацаагүй байгуулсан бөгөөд төвийн 2023 оны төсөвт тэтгэвэр тэтгэмжийн зардал тусгагдсан бол **“...55 нас хүрсэн эмэгтэй даатгуулагч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэвэр тогтоолгон авч болно.”** гэж заасан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан өндөр насны тэтгэвэрт гарах хүсэлтийг бичгээр гаргаж өгөхийг ажил олгогчийн зүгээс шаардах нь зүйтэй.

3. Хууль тогтоомжийн хүрээнд ЗСХ-ийн даргыг албан тушаалаас нь чөлөөлөх тохиолдолд төвийн дүрмийн **“6.7.8.бүтцийн нэгжийн даргыг томилж, чөлөөлөхөд төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Төрийн захиргааны удирдлагын асуудал хариуцсан нэгжтэй зөвшилцөж шийдвэрлэх;”**, Сайдын

2022.10.10-ны 17 дугаар шуурхай хуралдаанаас **“Бүх харьяа газрууд зөвхөн Сайдын зөвшөөрөлтэйгээр нэгжийн дарга, удирдлагуудыг өөрчлөх, томилж байх”** үүрэг даалгаврыг мөрдлөг болгон ажиллах шаардлагатай.

4. ЗСХ-ийн болон ажилтнуудын үйл ажиллагаанд хяналт тавих, удирдлагаар хангах үүрэг бүхий шууд харьяалан удирдах нэгжийн даргагүй байгаа нь нэгжийн ажлын гүйцэтгэл, үр дүнд шууд болон шууд бусаар нөлөөлж байна. Иймд энэхүү чиг үүргийг төвийн Захирал шууд хэрэгжүүлэх, эсхүл албан бусаар аль нэг нэгжийн даргаар хавсран гүйцэтгүүлэх боломжтой юм.

Нэгж, ажилтнууд дараах асуудалд анхаарч ажиллах шаардлагатай. Үүнд:

5. Хөдөлмөрийн дотоод журмын 5.1.5-д заасны дагуу ТНУАСХ, ГХБАБМХ төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд үндэслэж нэгжийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг шалгуур үзүүлэлт, зорилтот түвшин, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах ажилтнаар нарийвчлан боловсруулж баталж хэрэгжүүлэх;

6. ЗСХ-ийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2023.01.05-ны өдөр эйбл системд холбосон бөгөөд нэгжийн ажилтнууд төлөвлөгөөний хэрэгжилтийг хугацаанд нь хангаж ажиллах;

7. Хөдөлмөрийн тухай хуулийн 103.3.1-д заасны дагуу ажил мэргэжлийн жагсаалтыг 2022 оны VI сард шинэчлэн баталсан бөгөөд тус жагсаалтын дагуу албан тушаалын тодорхойлолтууд батлагдаагүй нь ажилтнуудын албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг тодорхой бус, ачаалал жигд бус байгаад анхаарч Хөдөлмөрийн тухай хуулийн 43.2.6, төвийн дүрмийн 6.7.4-т заасан “ажилтныг ажлаар хангаж, ... зааварчилгаа өгөх”, “...төвийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн байлгахад чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах” гэсэн ажил олгогчийн үндсэн болон удирдлагын эрх, үүргийг хэрэгжүүлэх;

8. ЗТХ-ийн сайдын 2023.01.09-ний өдрийн 1-р шуурхай хуралдаанаас өгсөн

a. Харьяа байгууллагууд албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтод Зам, тээврийн салбарын үйл ажиллагааг сурталчлах, хийгдэж буй ажлуудын үр дүн, ач холбогдлыг олон нийтэд таниулах чиглэлээр өөрчлөлт оруулах ажлыг зохион байгуулах.

b. Бүх харьяа байгууллагууд бүтэц, зохион байгуулалтын зөв хувилбар, оновчтой санал боловсруулж, шаардлагагүй орон тоог хасах, үр ашиггүй зардлыг бууруулж ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх санал, шийдэл гаргаж танилцуулах.

c. Салбарын албан хаагчдын орон сууцны барилгыг 2023 оны 10 дугаар сард багтаан ашиглалтад оруулах барилга угсралтын ажлын төлөвлөгөө, гэрээг гүйцэтгэгч компанитай байгуулж 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн дотор Төрийн нарийн бичгийн даргаар батлуулах үүрэг даалгаврыг оновчтой, үр дүнтэй хэрэгжүүлэх;

9. Төмөр замын тээврийн тухай хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсний дагуу УИХ-д 2023.01.10-ны өдөр өргөн мэдүүлсэн, хуулийн төсөлд төмөр замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хэрэгжүүлэх чиг үүрэгт ГТХЗНТ-ийн зарим чиг үүргүүд тусгагдсантай холбогдуулан ажилтнуудын дунд байгууллага татан буугдах нь, бүтцийн өөрчлөлт хийгдэх нь, ажлын байргүй болох нь гэсэн айдас, түгшүүр бий болсон нь ажиглагдаж байна.

10. Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэн батлахад тодорхой хугацаа шаардагдана, түүнчлэн хууль хүчин төгөлдөр болох хугацааг хуулийн төсөлд 2023.07.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тусгасан байсан тул 2023 оны эхний хагас хүртэлх хугацаанд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад чиглэсэн төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажлаа хэвийн үргэлжлүүлэх нь зүйтэй.

11. Мөн Төрийн албан хаагчийн шалгалтад бэлтгэх ажлыг хувь ажилтнаар бус, хамт олноор бэлтгэхээр зохион байгуулж, ажлын тодорхой өдөр, цагийг сонгож үр дүнтэй бэлтгэх;

12. Төмөр зам, далай ашиглалт, усан замын тээврийн стандартчиллын 2023-2024 оны төлөвлөгөө, АЕГ-аас зохион байгуулах албан хэрэг хөтлөлтийн анхан шатны мэдлэг болгох, мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөө, Төмөр замын мэргэжилтэй ажилтныг бэлтгэх, сургалт зохион байгуулах, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох, шалгалт авах журамд санал өгөх, албан бичигт заасан хугацаанд ЗТХЯ-нд хариу өгөх зэрэг цаг үеийн ажлуудыг хугацаанд гүйцэтгэх.

**ТАНИЛЦСАН:**

“ГТХЗНТ” УТУГ-ЫН ЗАХИРАЛ

А.БУЯННЭМЭХ

ТНУАСХ-ИЙН ДАРГА

Д.ТӨГСЖАРГАЛ

ГХБАБМХ-ИЙН ДАРГА

Ц.ОЮУНБАТ

**БОЛОВСРУУЛСАН:**

ХШҮМ

Э.ОСОРЖАМАА